



Digital Day of Outreach буюу Цахим Авралын Зарын Өдөрлөг

Өөрийн найз, дотны хүндээ Сайн Мэдээг цахим ертөнцөд энгийн бөгөөд сонирхолтой байдлаар танилцуулж, Есүс Христтэй холбоё.

ЯАГААД ЗААВАЛ ХАМТ НЭГ ДОР ЦУГЛАНА ГЭЖ?

Цахим Авралын Зарын хөтөлбөр нь хамтдаа нэг дор цуглаад онлайн ертөнцөд харилцан яриа өрнүүлдгээрээ бусад хувьчилсан Сайн Мэдээ тараалтаас ялгаатай. Ганц мод гал болдоггүйн адил итгэгч хүн ганцаараа байвал тусгүй. Харин бид хамтдаа байвал бие биенээ хурцалж урамшуулан, суралцдаг.

ХЭН ҮҮНД ОРОЛЦОЖ БОЛОХ ВЭ?

Та өөрийн чуулганы найз, дагалдагч, эсийн бүлгийнхэн, үерхдэг залуугаа (хэрвээ байдаг бол) дагуулан авчирч болно.

ЯГ ЮУ БОЛОХ БОЛ?

Энэ хөтөлбөрт та ирснээр маш сонирхолтой байдлаар Сайн Мэдээг тараах аргад суралцахаас гадна олон жилийн туршлагатай сургагч багшийн зөвлөгөө дор сургагдана. Мөн магтаал залбирал, цай кофе байхаас гадна мэдээж Сайн Мэдээгээ тараана. Нийгмийн болон Христитгэлт үйлчлэлийн салбарт ажиллаж буй туршлагатай удирдагч нар өөрсдийн гэрчлэлийг мөн хуваалцана.

ОНЛАЙНД ӨӨРИЙН ИТГЭЛЭЭ ЯАЖ ХУВААЛЦАХАА МЭДЭХГҮЙ БАЙВАЛ?

Айх аюулгүй. Бид танд туслана. Төрөл бүрийн жанрын сүнслэг яриа эхлүүлж, өрнүүлэхэд зориулагдсан богино хэмжээний кинонууд бидэнд бий. Та хөтөлбөрийн үеэр өөрийн ухаалаг төхөөрөмжинд кинонуудыг татаж авч болохоос гадна гэртээ аваад явж болно.

БИД ХЭНД САЙН МЭДЭЭГ ХУВААЛЦАХ ВЭ?

Интернэтэд онлайн байгаа хэнд ч хуваалцаж болно. Удаан уулзаагүй 10 жилийн найз, их сургуулийн найз, хол ойрын хамаатан, яриа өрнүүлэхээс эмээдэг ах эгч нар гэх мэт.

БИ ТЕХНОЛОГИЙН ТАЛ ДЭЭР САЙН МЭДЛЭГГҮЙ БОЛ ЯАХ ВЭ?

Санаа зоволтгүй. Ухаалаг утас, таблет эсвэл компьютертэй, мөн Фейсбүүктэй бол боллоо!

ИНГЭЭД ДАРААЛЛЫГ ТАНИЛЦУУЛЪЯ.



Залбир.

Дор хаяж 10 хүнтэй харилцана гэж бод.



Тэднийг сонс, ойлго.

Амьдралд нь юу тохиолдож байгааг болон ямар сүнслэг хэрэгцээ байгааг асууж мэд.



Бэлд.

Тэднийг сонсонгоо ямар киног хамт үзэж болох вэ гэдгийг бодох хэрэгтэй. Сонсогчийн сонирхол, одоогийн нөхцөл байдалтай уялдуулбал сайн байдаг.

Юу юу авчирах вэ?

Эдгээрийн аль нэгийг авчирвал болно:

- Нөүтбүүк
- Таблет
- Ухаалаг утас
- Дата сим
- WiFi цацагч төхөөрөмж
- Эдгээрийн цэнэглэгч, адапторууд